



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

---

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

**Аудитын код: ГСА-2017/01/СТА-ТЕЗ**

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ТӨСВИЙН  
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН  
2016 ОНЫ САНХҮҮГИЙН  
НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

**(2016 оны 12 дугаар сарын 31-нээр  
дуусгавар болсон)**

**2017.04.20**



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Г.БАТСУУРЬ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,  
Утас/Факс: (976) 7054 3179,  
E-mail: goviusumber@audit.gov.mn

2017-04-20 № 10111/2017/01-СТА-ТЭЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Аймгийн ТЭЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон, аккрузл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т заасан бүрэн эрхийн дагуу аудит хийв.

Аймгийн ТЭЗ нь тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, тэдгээрт нийцүүлэн гаргаж, Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь аймгийн ТЭЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргаж, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Аймгийн ТЭЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулга, холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

80203